

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2019 оны 12 дугаар сарын 04-ний өдөр

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Геологи хайгуулын өрөмдлөг, ГХА-ын ажлын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж ЭБМЗ-д хамгаалах, нөөц тогтоогдсон хэсэгт ашиглалтын тусгай зөвшөөрөл авах зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-007137 тоот “Улаан уул” талбайд геологи хайгуулын ажил хийж гүйцэтгэх, ажлын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан бичиж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хамгаалж баталгаажуулах, MV-000175 талбайд геологи хайгуулын гүний өрөмдлөгийн ажил хийж гүйцэтгэх, үр дүнгээр тайлан боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэснээр ТӨҮГ-ын харъяа Зэрэгцээ болон Шижир Алт алтны үйлдвэрийн алт олборлолтыг нэмэгдүүлэх, үйлдвэрийн бүтээмжийг өсгөх болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
 - Байгууллагын ерөнхий танилцуулга
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
 - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
4. Сүүлийн 2 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт.
5. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2019 оны 12 дугаар сарын 11–ний өдрийн 14 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2019 оны 12 дугаар сарын 11– ний өдрийн 14 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ

Хаяг: Улаанбаатар хот 51, ш/х – 002

Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө.

22-р хороо, “Монголросцветмет” ТӨҮГ-ын байр, 504 тоот,

И-мэйл: mailbox@monros.mn.

Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-458675, 976-11-450060-158